**АГУУЛГА**


1. **ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА......2**
2. **ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ......4**
3. **УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН ......6**
4. **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ......7**
5. **ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ......13**
6. **ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ......16**
7. **ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ……......20**
8. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ......24**
9. **УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ......28**
10. **ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ……......31**
11. **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ ……...33**
12. **ДҮГНЭЛТ ......35**
13. **ХАВСРАЛТ ......36**

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Услалтын систем байгуулах талбай нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт багийн нутагт, Хэрлэн сумын төвөөс баруун хойт зүгт агаарын зайгаар 45-55 км, Өлзийт багийн төвөөс баруун хойт зүгт 15-20 км зайд, Чандгана талд орших Их Өлзийт уулын зүүн урд Бага Өлзийт гэдэг газар Мөрөн голын өмнөд татмын тэгш гадаргатай тал газар далайн түвшнээс дээш 1150 метр өндөрт өргөгдсөн тэгш гадаргатай тал газар ХӨ47$^{0}$30$^{/}$40$^{//}$, ЗУ110$^{0}$01$^{/}$31$^{//}$ солбицолд оршино. Тус талбайн хойт талаар Хэрлэн-Өмнөдэлгэр чиглэлийн авто тээврийн шороон зам, өмнө талаар 10 км орчим зайтай Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн авто тээврийн АО501 дугаар хатуу хучилттай төв зам өнгөрнө.




*Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг*

- **Усалгааны системийн техникийн үзүүлэлт**

**Услалтын системийн нэр, хийцийн ангилал**: "Өлзийт-100 га", инженерийн хийцтэй, далд систем

**Услалтын системийн усны эх булаг**: Газрын доорх гүний ус.

**Услалтын системийн барилга, байгууламж**:

- ✓ Гүн өрөмдлөгийн худаг 3 ширхэг
- ✓ Худгаас усан санд ус дамжуулах даралтат, далд шугам хоолой, HDPE хуванцар яндан
- ✓ Ус хуримтлуулах, дамжуулах сан V= 9,591.0 $м^3$
- ✓ Цахилгаан хөдөлгүүртэй суурин насос станц
- ✓ Бороожуулагч машинд ус дамжуулах даралтат, далд шугам хоолой, HDPE хуванцар яндан
- ✓ Ус хуваарилах зангилааны, үзлэгийн болон юүлэх худгууд
- ✓ Бороожуулагч машины суурин, цамхагт гидрант
- ✓ Нэг төвийг тойрох хөдөлгөөн дундаа усалгаа хийдэг, тасралтгүй ажиллагаат, өргөн

авцат “СРІМ” загварын “LOVOL” маркийн бороожуулагч машин зэрэг болн



*Зураг 2. Усжуулалтын систем*

- **Ус хуримтлуулах, дамжуулах сан**

Усалгааны усны эх үүсвэр болох гүн өрөмдлөгийн 3 худгаас олборлосон усыг түр хугацаанд хуримтлуулан хадгалах зориулалтын усан сангийн барилгын хийцийн зохиомжийг Захиалагч байгууллагаас зураг төсөл зохиогчид өгсөн байна. Тиймээс, усан сангийн инженерчлэлийн тооцоог хийхдээ техникийн болон байгаль орчны тохижилтын хосолмол зориулалттай байх нөхцөлийг нэгэн зэрэг хангаж байх зорилгод нийцүүлэхэд анхаарч техникийн шийдлийн дараах хувилбарыг сонгосон байна.

- ✓ Усан сангийн нийт эзлэхүүн – 9,591.0 $м^3$;
- ✓ Усан сангийн ажлын эзлэхүүн – 8,226.0 $м^3$;
- ✓ Усан сангийн үл хөдлөх эзлэхүүн – 1,365.0 $м^3$;
- ✓ Усан сангийн эзлэхүүн нь хоёр хэсэгтэй байна;
    - Усан толио үүсгэх гадна эзлэхүүн;
    - Усалгааны ус хуримтлуулах дотор эзлэхүүн;
- ✓ Усан сангийн доторлогооны материал – геомембран;
- ✓ Усан толио үүсгэх гадна эзлэхүүнд худгийн усны булингар, хагшаасыг тунаана;
- ✓ Усан сангийн гадна эзлэхүүний усыг дотор эзлэхүүнд шилжүүлэх ус халиах босго;




*Зураг 3. Төслийн геологийн тогтоц*

## 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“М Агро” ХХК-ийн тариалангийн талбайн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2023 онд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Усалгаатай газар тариалангийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

***Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд***

**Гол сөрөг нөлөөллүүд:**

- Хаврын тариалалт, намрын уринш бэлтгэх үед агаарт тоосжилт үүсэх, улмаар цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 50-250 м зайд тархах, орчныг бохирдуулах (эвдэрсэн хөрс салхиар элэгдэх, нунтаг тоос орчинд тархах)

**Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Ургамал хамгааллын бодис, бордооны тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах, салхиар тарах зэргээр агаарын чанарт нөлөөлөх;
- Тухайн бодисыг хадгалах үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүй, автомат агааржуулалтын систем суурилуулаагүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх;
- Болзошгүй галын аюул, осол аваарын үед гарах хорт хийн дэгдэлт агаарын чанарт нөлөөлөх;
- Ургамал хамгааллын ихэнх бодисууд нь хор аюулын ангиллаар 1, 2, 3-р зэрэглэлд хамаарах хортой бодис бөгөөд шатамхай биш чанартай боловч гал авалцах материалтай хамт байвал хүчтэй исэлдүүлэгч болж аммонийн нитрат, аммиак, азотын хүчил, хортой азотын исэл болон задарч болзошгүй тул агаар дуслын замаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх;

***Усны чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд***

**Гол сөрөг нөлөөллүүд:**

- Газар тариалангийн усалгаанд ашиглах газрын доорх усыг ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнээс хэтрүүлэн ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох;

**Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Тариалангийн талбайн гүний худгуудын усны эх үүсвэрт ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох;
- Бордооны хэрэглээнээс үүдэлтэй фосфор хөрсөнд бэхжих, азотууд өндөр уусах чадвартай тул газрын гүний усны чанарт нөлөөлөх;
- Химийн бодис хадгалах агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах;
- Ургамал хамгааллын ихэнх бодисууд нь усан орчинд богино хугацааны хурц хоруу чанартай, архаг хоруу чанартай, усны амьд организмд хортой 1, 2, 3-р зэрэглэлд хамаарах бодисууд тул ургамал

хамгааллын бодис ба бордооны тээвэрлэлт, хадгалалтыг зохих шаардлагын дагуу явуулахгүй бол усан орчинд богино хугацааны нөлөөлөл үзүүлэх;

- Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс ургамал хамгааллын бодис бордоог түр урсцын голдирлуудад алдах, бохирдлын эх үүсвэрийг бий болгох;

***Хөрсний чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл***

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Төслийн хүрээнд ашиглагдах трактор, комбайн, техник механизм болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулаагүйгээс олон салаа зам гарах, хөрсний талхагдал үүсэх;

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Шатах, тослох материалыг цэнэглэх, түр хадгалах үед хөрсөн алдагдвал хөрсөн бүрхэвч бохирдох;
- Ургамал хамгааллын бодис, бордооны агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх;
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдвал ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, хөрсний бичил биетэнд нөлөөлөх дам нөлөөлөх;

***Ургамлан бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл***

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Төслийн хүрээнд ашиглагдах трактор, комбайн, техник механизм болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулаагүйгээс олон салаа зам гарах, хөрсөн бүрхэвч талхлагдах, ургамлан нөмрөг устах;

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Шатах, тослох материалыг цэнэглэх, түр хадгалах үед хөрсөн алдагдвал ургамлан нөмрөг бохирдох;
- Ургамал хамгааллын бодис, бордооны агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын хадгалалтын горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөх;
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдвал ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, хөрсний бичил биетэнд нөлөөлөх дам нөлөөлөх;

***Биологийн төрөл зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл***

**Гол сөрөг нөлөөлөл:**

- Төслийн үйл ажиллагааны үед ашиглах машин механизм, автомашинуудын хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, гэрэл, утаа, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох тоосжилт зэргээс үүдэн тухайн ажил явагдаж байгаа газрын ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах;
- Усалгаатай газар тариалан, түүнийг дагасан үндсэн болон туслах барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, газар шорооны ажлын үед мэрэгч болон мөлхөгч амьтдын амьдрах орчин устаж үгүй болох, too толгой цөөрөх;

## 3. УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ГОЛ ҮР ДҮН

Хэнтий аймгийн Хэрлэн суманд орших Усалгаатай газар тариалангийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 19-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн илэрхийлэв.  2025 онд нийт 26 ажил төлөвлөснөөс 24 ажлын бүрэн биелэлтийг хангаад байна.

*Хүснэгт 1 Байгаль орчны менежмент төлөвлөгөөд тусгагдсан ажлуудын хэрэгжилт*

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төрөл | Төлөвлөсөн ажлын тоо | Гүйцэтгэсэн ажлын тоо | Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 6 | 6 | - |
| 2 | Орчны тохижилт, ногоон байгууламж | 1 | 1 | - |
| 3 | Осол, эрсдэлийн менежмент | 4 | 4 | - |
| 4 | Хог хаягдлын менежмент | 3 | 3 | - |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 4 | 4 | - |
| 6 | Удирдлага зохион байгуулалт | 5 | 3 | 1 |
| 7 | Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа | 3 | 3 | - |
| **Нийт** | | **26** | **25** | - |

## 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

М Агро ХХК нь Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 6 ажлыг тусган оруулж биелэлтийг ханган ажиллав.

<table>
<tr><th>№</th><th>Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө</th><th>Ажлын гүйцэтгэл</th><th>Зураг</th></tr>
<tr><td colspan="4">4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ</td></tr>
<tr><td>4.1.1.</td><td>Газар тариаланд ашиглаж буй машин механизмын хүлэмжийн хийн ялгарлыг тооцох дата мэдээллийг цуглуулах</td><td>Хүлэмжийн хийн тооллогыг олон улсын түвшин дэх суурь аргачлал болох "Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын Мэргэжилтний Хороо(IPCC)-ны 2006 оны аргазүй", аж ахуйн түвшинд түгээмэл ашиглагддаг "Хүлэмжийн хийн Протокол (GHG Protocol)-ийн арга зүй"-д тус тус тулгуурлан газар тариаланд ашиглаж буй нийт техникийн түлшний зарцуулалтын дата мэдээллийг<br><br>2025 оны 01-р сараас 04-р сар хүртэлх дата мэдээллийг цуглуулан тооцож байна.<br>Нийт М Агро ХХК-д ашиглаж байгаа техникийн түлш зарцуулалт, нийт гүйлт, мот.цагуудыг бүртгэн тооцоолол хийхэд бэлтгэж байна.<br><br>Хавсралт 1. Дата цуглуулалтын товч тайлан, мэдээг хавсаргав.</td><td>

Зураг 1. Дата цуглуулалтын график үзүүлэлт</td></tr>
<tr><td colspan="4">4.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 4.2.1 | Ашиглалтын зориулалтаар ашиглаж буй худгийн тоолууранд бичиглэл хийж, Хэрлэн сумын байгаль хамгаалагч, татварын албанд усны тоолуурыг хянуулах, холбогдох төлбөрийг барагдуулах | Газар тариалангийн үйл ажиллагаанд ашиглаж буй ашиглалтын 3 ширхэг худаг, бордооны 2-р талбайн худгуудын тоолууранд бичиглэл хийж, Хэрлэн сумын байгаль хамгаалагч, татварын албанд усны тоолуурыг 09-р сарын байдлаар хянуулан баталгаажуулаад байна.<br><br>2025 оны 05-р сараас 09-р сарын хооронд үйл ажиллагаа явуулсан бөгөөд энэ хугацаанд тоолуурын заалтаар нийт 201,395 м3 ус ашиглаад байна.<br><br>*Хавсралт 2. 1-9-р сарын тоолуурын бичиглэлийг хавсаргав.* | *Зураг 2. 1-9 сарын Тоолуурын бичиглэл хийж баталгаажуулсан байдал* |



ТООЛУУРЫН № 1 1002а 1 худаг

2025 ОНД АШИГЛАСАН УСНЫ ЗАРЦУУЛАЛТ

| № | Огноо | Тоолуурын заалт | Зөрүү | Төлбөр /төг/ | Тайлбар | Бичилт хийсэн | Ашиглагчийг төлөөлж байлцсан | Хянасан татварын байцаагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ........ оны ........ сарын эцсийн тоолуурын заалт ........ | | | | | | Гарын үсэг | |
| 1 | 1 сар | 0 | | | | | | |
| 2 | 2 сар | – | | | | | | |
| 3 | 3 сар | – | | | | | | |
| 4 | 4 сар | – | | | | | | |
| 5 | 5 сар | 229895 | 17706 | 1505895,3 | | | | |
| 6 | 6 сар | 231391 | 1496 | 127,234,8 | | | | |
| 7 | 7 сар | 241263 | 9872 | 839,613.6 | | | | |
| 8 | 8 сар | 242055 | 792 | 67,359,6 | | | | |
| 9 | 9 сар | 248924 | 6869 | 584,208.4 | 3,124,311.7 | | | |
| 10 | 10 сар | | | | | | | |
| 11 | 11 сар | | | | | | | |
| 12 | 12 сар | | | | | | | |
| | Нийт | | | | | | | |

Таних тэмдэг: Тоолуур эвдэрсэн бол (-) Ажлаагүй бол (+)



ТООЛУУРЫН № 1 2002а 2 худаг

2025 ОНД ХЭРЭГЛЭСЭН УСНЫ ЗАРЦУУЛАЛТ

| № | Огноо | Тоолуурын заалт /м3/ | Зөрүү | Төлбөр /төг/ | Тайлбар | Бичилт хийсэн | Ашиглагчийг төлөөлж байлцсан | Хянасан татварын байцаагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ........ оны ........ сарын эцсийн тоолуурын заалт ........ /м3/ | | | | | | Гарын үсэг | |
| 1 | 1 сар | 0 | | | | | | |
| 2 | 2 сар | - | | | | | | |
| 3 | 3 сар | - | | | | | | |
| 4 | 4 сар | - | | | | | | |
| 5 | 5 сар | 160945 | 6971 | 592,883.55 | | | | |
| 6 | 6 сар | 190327 | 29382 | 2,498,939.1 | | | | |
| 7 | 7 сар | 209848 | 19521 | 1,660,261.05 | | | | |
| 8 | 8 сар | 226088 | 16240 | 1,381,212 | | | | |
| 9 | 9 сар | 233517 | 7429 | 631,836.45 | 6,765,132.15 | | | |
| 10 | 10 сар | | | | | | | |
| 11 | 11 сар | | | | | | | |
| 12 | 12 сар | | | | | | | |
| | Нийт | | | | | | | |



ТООЛУУРЫН № 1 2002а 3 худаг

2025 ОНД ХЭРЭГЛЭСЭН УСНЫ ЗАРЦУУЛАЛТ

| № | Огноо | Тоолуурын заалт /м3/ | Зөрүү | Төлбөр /төг/ | Тайлбар | Бичилт хийсэн | Ашиглагчийг төлөөлж байлцсан | Хянасан татварын байцаагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ........ оны ........ сарын эцсийн тоолуурын заалт ........ /м3/ | | | | | | Гарын үсэг | |
| 1 | 1 сар | 0 | | | (+) | | | |
| 2 | 2-сар | - | | | (+) | | | |
| 3 | 3-сар | - | | | (+) | | | |
| 4 | 4-сар | - | | | (+) | | | |
| 5 | 5-сар | 170564 | 16449 | 1,398,987.45 | | | | |
| 6 | 6-сар | 182241 | 11677 | 993,128.85 | | | | |
| 7 | 7-сар | 200227 | 17986 | 1,529,709.3 | | | | |
| 8 | 8-сар | 218392 | 18165 | 1,544,933.25 | | | | |
| 9 | 9-сар | 236622 | 18230 | 1,550,461.5 | 7,017,220.35 | | | |
| 10 | 10-сар | | | | | | | |
| 11 | 11-сар | | | | | | | |
| 12 | 12-сар | | | | | | | |
| | Нийт | | | | | | | |

Таних тэмдэг: Тоолуур эвдэрсэн бол ( - ) Ажлаагүй бол (+)

| | | | |
|---|---|---|---|
| | | | БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ<br>ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ<br>ДАРГЫН ТУШААЛ<br>2025 оны 12 сарын 25 өдөр Дугаар А/47 Хэрлэн сум<br>**Зөвшөөрөл олгох тухай**<br>Монгол улсын Усны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын А/618 дугаар тушаал зэргийг үндэслэн ТУШААХ нь:<br>1. Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дугаар Е-2511-000169 "Өлзийт-200" усалгаатай газар тариалан төслийн ус ашиглуулах дүгнэлтийн дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын 7 баг, Өлзийт тосгонд орших "Өлзийт-200" усалгаатай газар тариалан төсөлд ашиглах 504,059.76 $м^3$ газрын доорх усыг 2025 оныг дуустал хугацаанд авч ашиглахыг "М Агро" ХХК-д зөвшөөрсүгэй.<br>2. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын доорх усны нөөц, ашиглалт хариуцсан мэргэжилтэн /У.Жамбалдагва/-д үүрэг болгосугай.<br>3. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Хэрлэн голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулахыг "М Агро" ХХК-ийн Чандгана салбарын захирал /Л.Баттөгс/-д даалгасугай.<br>4. Усны тухай хуулийн 30 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтын дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг хангаж ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, ус ашиглалтын тайланг 2025 оны 12 дугаар сарын 31-ний дотор Сав газрын захиргаанд ирүүлж, ус ашиглах гэрээний биелэлтийг дүгнүүлэхийг "М Агро" ХХК-ийн Чандгана салбарын захирал /Л.Баттөгс/-д даалгасугай.<br>ДАРГА Б.НАНДИНЦЭЦЭГ<br>2325010073<br>БАТЛАВ.<br>ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА<br>/Б.НАНДИНЦЭЦЭГ/<br>БАТЛАВ.<br>"М АГРО" ХХК-ИЙН САЛБАРЫН ЗАХИРАЛ<br>/Л.БАТТӨГС/<br>**УС АШИГЛАХ ГЭРЭЭ**<br>2025 оны 12 сарын 24-ны өдөр Дугаар: 26 ЖА-25-156 Чингис хот<br>**Нэг. Ерөнхий зүйл**<br>Усны тухай хуулийн 28.4, 29.1-д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын гаргасан 2025 оны 12 сарын 22-ны өдрийн Е-2511-000169 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хэрлэн голын сав газрын захиргааны олгосон 2025 оны 12 сарын 25 –ны өдрийн А/47 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн,<br>Ус ашиглуулагчийг төлөөлж: Монгол Улс, Хэрлэн голын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц, ашиглалт хариуцсан мэргэжилтэн У.Жамбалдагва,<br>Ус ашиглагчийг төлөөлж: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Централ парк 8-р давхар, улсын бүртгэлийн 9011339041, 5573548 регистрийн дугаартай "М Агро" ХХК-ийн Чандгана салбарын захирал Л.Баттөгс нар (хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэх) ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.<br>**Хоёр. Гэрээний гол нөхцөл**<br>2.1 Ус ашиглах зориулалт: "Өлзийт-200" усалгаатай газар тариалан төсөл газрын доорх усны нөөцийг ашиглана.<br>2.2 Ашиглах усны хэмжээ: 504,059.76 $м^3$<br>2.2.1. Хөх тариа, хошуу будааны холимог тариалалтын усалгаанд 408,000 $м^3$<br>2.2.2. Царгас тариалахад ашиглах усалгаанд 90,000 $м^3$<br>2.2.3. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд 5,718.01 $м^3$<br>2.2.4. Ургамал хамгааллын бодист ашиглах усны хэмжээ 341.76 $м^3$<br>2.3. Усны чанар, найрлага: Усны эх үүсвэр болох худгаас дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг Сав газрын захиргаанд ирүүлнэ. "Ундны ус, эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт" MNS 900:2018 стандартын шаардлагад нийцсэн усыг унд ахуйд хэрэглэх, шаардлагатай тохиолдол ус цэвэршүүлэх багаж төхөөрөмж суурилуулах<br>2.4. Усны эх үүсврийн байршил: Хэрлэн сум 7 дугаар баг, Өлзийт тосгоноос баруун зүгт 10км-т Үйлдвэрлэлд шаардагдах усыг төслийн талбайд байрлах 5 худгаас газрын доорх ус ашиглана.<br>Барилга байгууламж: Нэгж талбарын 2311036569 дугаар бүхий 139.677м.кв /га/ талбай, нэгж талбарын 2311036570 дугаар бүхий 30.0м.кв /га/ талбай, нэгж талбарын 2311036571 дугаар бүхий 10.0м.кв /га/ талбайг услалтын систем, төвийн эргэлтэт бороожуулагч машины услах нийт талбайн хэмжээ 100 га бөгөөд тариалангийн талбайд орших 3 ш гүний худгаас ус татан 9,591 $м^3$ эзэлхүүнтэй ус хуримтлуулах цөөрөмд хуримтлуулан талбайн усалгааг хийнэ.<br>Усан санг HDPE геомембранаар доторлосон. Гүний худгаас татсан ус шаардлагатай хэмжээнд хүрээгүй тохиолдолд Мөрөн голын усыг хуримтлуулан усан сан руу татна. Бороожуулах машины хөдөлгөөнгүй тулгуур нь 3.2x3.2 хэмжээтэй 1 м өндөр хөлтэй төмөр бетон суурь байна. Худгаас ус татах хоолой D100 мм байна. Гол шугам хоолойн төгсгөлд юүлэх шингээх худаг байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 4.2.2 | Мөрөн голын экологийн урсацын үнэлгээ хийх , шавхалт туршилтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Бид усалгаатай газар тариалангийн ус ашиглалтаас “**Мөрөн голын экологийн урсац болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг тооцох судалгаа”-г** хийлгүүлэх зорилгоор “Сантгидро Консалтинг” ХХК –тай хамтран ажлын даалгаврыг боловсруулан ЗГХА Усны газраар батлуулж, 2025 оны 04-р сараас 08-р сар хүртэл судалгааны ажлыг хийж дуусгаад байна.<br><br>Уг судалгааны үйл явцыг ЗГХА Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Б. Мөнгөнтуул, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын ахлах Б. Гантогтох, МУ-ын усны зөвлөх инженер Х. Гарамханд нар ирж шалгалт хийж, шүүмж зөвлөгөөг өгч ажиллав.<br><br>*Хавсралт 3. Судалгааны үйл явц дүгнэлт хэсгийг хавсаргав.* | <br>*Зураг 3. Усны судалгааны үйл явц* |

| | | | |
|---|---|---|---|
| | | | <br>*Зураг 4. Шинжээч нар хянаж буй байдал* |
| 4.2.3 | Эрүүл ахуйн бүсийг тогтоолгох | Усны тухай хуулийн дагуу газар тариалангийн ашиглалтын 3 худагт эрүүл ахуйн бүс тогтоолгох тухай албан хүсэлтийг хүргүүлсэн бөгөөд ашиглалтын 3 худаг нь төслийн талбайн хашаан дотор байршилтай, худгийн ойр орчимд хортой нөхцөл байхгүй, дээд хэсгээрээ бетоноор хүрээлэгдсэн байдлыг Хэрлэн голын сав газрын мэргэжилтэн нар шалгаж үзэн, эрүүл ахуйн бүс тогтоох шаардлаггүй гэж үзэв.<br><br>*Хавсралт 4. Хэрлэн голын сав газрын албан хүсэлтийг хавсаргав.* | <br>БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ<br>ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА<br>УЦУОШТөвийн 1 дугээр давхар, Тэмүүжингийн гудамж<br>Булаг баг, Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23125<br>Утас: (976) 7056-3696<br>Цахим шуудан: kherlenrba@gmail.com<br>2025.09.30 № 1/146<br>танай 2025.09.19-ны № 02/388 -т<br>М-АГРО ХХК-Д<br><br>Монгол улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэгт төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоохоор заасан байдаг.<br><br>Танай компанийн газар тариалангийн ашиглалтын 3 гүний худгийн хувьд төслийн талбайд, худгийн ойр орчимд хортой нөхцөл байхгүй, дээд хэсэгтээ бетоноор хүрээлэгдсэн, хамгаалалт, битүүмжлэл сайтай зэргийг үндэслэн эрүүл ахуйн бүс тогтоох шаардлагагүй гэж үзэж байна.<br><br>ДАРГА Б.НАНДИНЦЭЦЭГ<br>232503100<br>*Зураг 5. Хэрлэн голын сав газрын албан бичиг* |

| **4.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ** | | | |
|---|---|---|---|
| 4.3.1 | Төслийн хүрээнд ашиглагдах трактор, комбайн, техник механизм болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах, замыг тэмдэгжүүлэх | Газар тариалангийн талбайн үйл ажиллагаанд ашиглах нийт тээврийн хэрэгслийн замын маршрутыг тодорхойлж замын тэмдэг тэмдэглэгээг 2023 оноос эхлэн байршуулан сайжруулсаар байна.<br><br>Мөн тайлант хугацаанд кемпээс газар тариалангийн 3-р талбай, махны үйлдвэрлүү явах 3.5 км замыг мэргэжлийн байгууллагаар сайжруулсан шороон замыг гүйцэтгүүлэв. |  *Зураг 6. Газар тариалангийн замын тэмдэглэгээ*<br> *Зураг 7. Сайжруулсан шороон замын харагдах байдал* |

| **4.4. Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ** | | | |
|---|---|---|---|
| 4.4.1 | Тарваганы судалгаа, ЦДШугамаас бүргэд шувуунд нөлөөлөх үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | 2025 оны 04-р сараас эхлэн Монголика ХХК-аар мэргэжлийн байгууллагатай хамтран газар тариалангийн талбай дахь тарваганы судалгаа болон төслийн ЦДШ-уудаас шувуунд нөлөөллөх нөлөөллийг тогтоох зорилготой үнэлгээ, судалгаа, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гаргуулан ажиллаж байна.<br>**Хаврын судалгаа:** Монгол тарваганы хаврын судалгааг 2025 оны 4-р сарын 17-21 хооронд хийж гүйцэтгэв. Өмнөх тайланд дурьдсанаар 5 бодгаль бүртгэсэн бол энэ удаагийн судалгаагаар тус компанийн төслийн талбай буюу кемпээс 5 км-ийн радиус дотор монгол тарвага бүртгэгдээгүй, 10 км-ийн радиуст 3-4 байршилд, кемпээс 40 орчим км-ийн зайд буюу төслийн 3-р талбай дотор мөн 2-3 байршилд нийт 54 толгой монгол тарвага бүртгэв. Тухайлбал: Кемпээс баруун урд Хөх харгуй хэмээх газарт 1 бүл 3 бодгаль, баруун хойно Их Өлзийт уулын Мөрөн гол дагуух хормойгоор 3-4 бүлийн 16 бодгаль, чанх хойд төслийн 1-р талбай дотор 1 бүл 2 бодгаль, төслийн 3-р талбайд үндсэн 2 байршилд 7-8 бүлийн 33 бодгаль урьдчилсан байдлаар ажиглагдав.<br><br>*Хавсралт 5. Тарвага болон шувууны судалгааны товч тайланг хавсаргав.* | <br>*Зураг 7. Тарваганы судалгааны байршлыг Google earth-д харуулсан байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| | | | <br>*Зураг 8. 2023 онд Газар тариалангийн талбайд байршуулсан үүрэн дээр шувуу байрласан байдал*<br><br>*Зураг 9. Газар тариалангийн талбай орчим үзэгдсэн шувууны судалгаа* |

## 5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

М Агро компани Хэнтий аймгийн Хэрлэн суманд байрлах 1.7 га мод үржүүлгийн талбайдаа 6 төрөл, зүйлийн мод, сөөгийг мөчир болон үрээр тарин бойжуулж байна.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|---|
| 5.1 | Газар тариалангийн хашаалсан талбайн ойн зурвасын нөхөн тарилтыг хийх, нэмэлтээр мод тарих | Ойн зурвасын талбай дахь 25.72 км-т таригдсан модны нөхөн тарилтын ажлыг **05-р сарын 10-наас 06-р сарын 18-ны** хооронд хийж гүйцэтгэсэн бөгөөд өөрсдийн бойжууллагын талбайд 2 жил болсон 3 төрөл зүйлийн хайлаас, бургас, улиас гэсэн 24,620 ширхэг модыг нөхөн тарилтаар тарьж, ургуулсан.<br><br>**2025 оны 10-р сарын 15-наас** эхлэн намрын тарилалтаар 5.2 км ойн зурвасын талбайд нэмэлтээр 5100 ширхэг улиас тарьсан. | <br>*Зураг 10 . Хаврын нөхөн тарилт хийгдэж буй байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| | | | <br>*Зураг 11 . Усалгаа, арчилгаа хийж буй байдал* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | <br><br>*Зураг 12 . Намрын тарилт хийж буй байдал* |

## 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй болно. Газар тариалангийн талбайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай Сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана. 2025 онд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр үргэлжлэн хийгдэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд цаашид түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр тухай бүр шаардлагатай арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх осол эрсдэлийг бууруулах зорилгоор тогтмол хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна. Аюул, ослыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах, залруулах, сайжруулах гэсэн зарчмаар явагдаж байна.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|---|
| 7.1 | Ургамал хамгаалах бодис, бордооны агуулахад үзлэг, шалгалтыг тогтмол хийх | Тайланд онд ургамал хамгаалах бодисын агуулах болох нийт 1315.40 м2 талбайг тохижуулан, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.<br><br>Мөн агуулахын үзлэгт 04-р сар болон 09-р саруудад аюулгүй байдлын үзлэг шалгалтыг хийж ажилласан.<br><br>*Хавсралт 6. УХБ-ын агуулахад үзлэг шалгалт хийсэн ажлын тайланг хавсаргав.* |  |

| | | | |
|---|---|---|---|
| | | |    *Зураг 13. Ургамал хамгаалах бодисын агуулахыг сайжруулсан байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| 7.2 | Ургамал хамгааллын бодистой харьцан ажиллагсдад сургалт зохион байгуулах | Ургамал хамгааллын бодистой харьцан ажиллагсад болох агрономич болон бусад ажилтан нарт аюулгүй ажиллагааны зааварчилгаа сургалтыг тогтмол өглөө бүр өгч, 2025 оны 04-р сард нийт ажилчдын сургалтыг зохион байгуулав. Сургалтаар нийт 100 гаруй ажилчид хамрагдав.<br><br>*Хавсралт 7. УХБ-ын аюулгүй ажиллагааны сургалт авсан бүртгэлийг хавсаргав.* | <br>*Зураг 14 . Аюулгүй ажиллагааны сургалт орж буй байдал* |
| 7.3 | ХАБЭА-н аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол ажлын өмнө өгөх | М Агро ХХК нь ХЭМАБ-н бодлогын хүрээнд аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол хийж хэвшсэн бөгөөд нийт ажилчид ажилд гарахын өмнө “Safety share” үйл ажиллагаанд орох бодлого зааварын дагуу явж байна.<br><br>*Хавсралт 8. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан хуудасыг 7-10 сар хавсаргав.* | <br>*Зураг 15. Газар тариалангийн албанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч буй байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| 7.4 | Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг онцгой байдалтай хамтран нийт ажилтнуудад орох | 2025 оны 04-р сард Хэнтий аймгийн Онцгой байдлын албатай хамтран нийт ажилчдад галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх практик болон онолын сургалтыг зохион байгуулан оров.<br><br>Мөн Аймгийн Засаг даргын нэрэмжит Гамшгийн бэлэн байдлын үзлэг Өлзийт тосгонд 2025-3-21-ний өдөр зохион байгуулагдлаа. Тайланд онд тосгоны ЗАА-ны хүсэлтээр галын багаж хэрэгслүүдээр дэмжлэг үзүүллээ. | <br>*Зураг 16 . Нийт ажилчдад галын сургалт, зааварчилгаа орж буй байдал*<br><br>*Зураг 17 . Өлзийт тосгоны Гал унтраах арга хэмжээнд багаж хэрэгслээр хангасан байдал* |

## 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Усалгаатай газар тариалангийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал нь ургамал хамгаалах бодисын сав баглаа боодол байна. Энгийн болон аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт түр хадгалаж байна.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|---|
| 8.1 | **Энгийн хог хаягдал:**<br><br>Газар тариалангийн талбайн орчим хог хаягдлын цэвэрлэгээний ажил зохион байгуулах | 2025 оны **04-р сар болон 09-р сарууддад** газар тариалан болон бусад аж ахуйн үйл ажиллагааны гадна талбай орчим их цэвэрлэгээг хийж гүйцэтгэсэн.<br><br>Нутгийн иргэд ахуйн хогоо эмх замбараагүй хаяхаас гадна ҮБАА-д үхэр нийлүүлсэн иргэд тэвшин дээрх өтөг бууцаа ойр орчмын хонхор, жалга бараадуулан асгаж орчныг бохирдуулах нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан компаниас Хар нуурын Аянгын хонхор, Бага өлзийтийн гармын дэргэд үүссэн хог, шатсан машины үлдэгдэл зэргийг 2025-10-23-ны өдөр цэвэрлэж тосгоны байгаль орчин хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөв. | <br><br>*Зураг 18. 04-р сарын нийтийн их цэвэрлэгээ хийж буй байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| | | |  *Зураг 19. 09-р сард нийтийн их цэвэрлэгээ хийж буй байдал* |
| 8.2 | **Аюултай хог хаягдал:** Аюултай хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд түр хадгалах | Засварын төвийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг засварын төвд байрлах "Аюултай хог хаягдлын цэг"-т түр хадгалаж, бүртгэлийг хийж байна. *Хавсралт 9. 2025 оны Аюултай хог хаягдлын бүртгэл 01-р сараас 10-р сар, УХБ-ын зарцуулалтын тайлан хавсаргав.* |   *Зураг 20 . Аюултай хог хаягдлын түр цэг* |

<table>
<tr>
<td>8.3</td>
<td>Ургамал хамгаалах бодисын хаягдал сав баглаа боодлыг Нийлүүлэгч байгууллагуудад хүлээлгэн өгөх байдлаар гэрээ байгуулах</td>
<td>Тайланд онд Газар тариалангийн үйл ажиллагаанд ашиглах ургамал хамгаалах бодисыг дотоодын тусгай зөвшөөрөлтэй Агромашитек ХХК, Энсада ХХК, Агротрейд ХХК, Цэцүүх ХХК байгууллагаас худалдан авах гэрээ хийж, гэрээнд өөрсдийн нийлүүлсэн хаягдал сав баглаа боодлыг буцаан хүлээлгэн өгөх, устгалыг нийлүүлэгч байгууллага хариуцах байдлаар хамтран ажиллаж байна.<br><br>Тайлант онд Энсада ХХК байгууллагад нийт 0.15 тн шуудайн хаягдлыг гэрээний дагуу буцаан нийлүүлээд байна.<br><br>Хавсралт 10. Ургамал хамгаалах бодис нийлүүлсэн байгууллагын нэмэлт гэрээг хавсаргав.</td>
<td>


БАТЛАВ.<br>“М АГРО” ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Б.СОЛОНГО<br><br>БАТЛАВ.<br>“АГРОМАШТЕХ” ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Б.ЭНХТӨР<br><br>БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ<br>НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ<br><br>2025 оны 02-р сарын 18-ны өдөр № МА-CF-25-009-001 Улаанбаатар хот<br><br>Энэхүү Бараа худалдах, худалдан авах гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ийг<br>нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5573548 тоот дугаартай “М АГРО” ХХК түүнийг төлөөлж Худалдан авалтын албаны дарга Ц.Баттүшиг (цаашид "Захиалагч" гэх),<br>нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5203449 тоот дугаартай "АГРОМАШТЕХ" ХХК түүнийг төлөөлж Салбарын захирал Г.Сүхбат (цаашид "Нийлүүлэгч" гэх) нар (хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Талуудын хооронд байгуулагдсан 2025 оны 02-р сарын 04-ний өдрийн MA-CF-25-009 тоот "Бараа худалдах, худалдан авах гэрээ" (цаашид "Үндсэн гэрээ" гэх)-г тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.<br><br>Нэг. Нэмэлт өөрчлөлт<br><br>1.1. Талууд Үндсэн гэрээний Хавсралт №2 Тусгай нөхцөл дэх 5 дугаар зүйлд “5.3 Захиалагч нь хэрэглэж дууссан бодисын савыг зориулалтын цэгт түр хадгалж, Нийлүүлэгчид буцаан өгөх ба Нийлүүлэгч нь буцаан авсан хаягдал сав баглаа боодлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч хуульд заасан арга хэлбэрээр устгуулах үүргийг хүлээнэ” гэж нэмэлтээр оруулахаар харилцан тохиролцов.<br>1.2. Энэхүү Гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг болох ба Гэрээгээр өөрчлөөгүй бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.<br><br>


БАТЛАВ.<br>“М АГРО” ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Б.СОЛОНГО<br><br>БАТЛАВ.<br>“ЭНСАДА ТРАКТРОН” ХХК-ИЙН<br>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br>Д.ОРГИЛ<br><br>БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ<br>НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ<br><br>2025 оны 03-р сарын 10-ны өдөр № МА-CF-25-006-001 Улаанбаатар хот<br><br>Энэхүү Бараа худалдах, худалдан авах гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ийг<br>нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5573548 тоот дугаартай “М АГРО” ХХК түүнийг төлөөлж Худалдан авалтын албаны дарга Ц.Баттүшиг (цаашид "Захиалагч" гэх),<br>нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 4255801 тоот дугаартай "ЭНСАДА ТРАКТРОН" ХХК түүнийг төлөөлж Үр, ургамал хамгааллын бодис, бордоо борлуулалтын албаны менежер Б.Баяртогтох, (цаашид "Нийлүүлэгч" гэх) нар (хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Талуудын хооронд байгуулагдсан 2025 оны 02-р сарын 04-ний өдрийн MA-CF-25-006 тоот “Бараа худалдах, худалдан авах гэрээ" (цаашид "Үндсэн гэрээ" гэх)-г тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.<br><br>Нэг. Нэмэлт өөрчлөлт<br><br>1.1. Талууд Үндсэн гэрээний Хавсралт №2 Тусгай нөхцөл дэх 5 дугаар зүйлд<br>“5.3 Захиалагч нь хэрэглэж дууссан бодисын савыг зориулалтын цэгт түр хадгалж, Нийлүүлэгч нь тээвэрлэлтийг хариуцан очиж авах бөгөөд буцаан авсан сав баглаа боодлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч хуульд заасан арга хэлбэрээр устгуулах үүргийг хүлээнэ. Сав баглаа боодлыг очиж авах, эрх бүхий байгууллагад хүргэх тээвэрлэлтийн зардлыг Талууд тэнцүү хэмжээгээр хариуцна.<br>5.4 Нийлүүлэгч нь тээврийн зардлын нэхэмжлэхийг зардал гарсныг нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлэх ба ирсэн нэхэмжлэхийг үндэслэн Захиалагч төлбөрийг шилжүүлнэ” гэж нэмэлтээр оруулахаар харилцан тохиролцов.<br>1.2. Энэхүү Гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг болох ба Гэрээгээр өөрчлөөгүй бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
</td>
</tr>
</table>



БАТЛАВ.
“М АГРО” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.СОЛОНГО

БАТЛАВ.
“ЭМ И СИ ТИ ЭС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ТҮВШИНБААТАР

**БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ**

2025 оны 02-р сарын 18-ны өдөр № МА-CF-25-003-001 Улаанбаатар хот

Энэхүү Бараа худалдах, худалдан авах гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ийг

нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5573548 тоот дугаартай “М АГРО” ХХК түүнийг төлөөлж Худалдан авалтын албаны дарга Ц.Баттүшиг (цаашид "**Захиалагч**" гэх),

нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5577055 тоот дугаартай "ЭМ И СИ ТИ ЭС" ХХК түүнийг төлөөлж Хөдөө аж ахуйн асуудал хариусан менежер И.Наранцогт (цаашид "**Нийлүүлэгч**" гэх) нар (хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Талуудын хооронд байгуулагдсан 2025 оны 01-р сарын 28-ны өдрийн МА-CF-25-003 тоот “Бараа худалдах, худалдан авах гэрээ” (цаашид "**Үндсэн гэрээ**" гэх)-г тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нэмэлт өөрчлөлт**

1.1. Талууд Үндсэн гэрээний Хавсралт №2 Тусгай нөхцөл дэх 5 дугаар зүйлд “5.3 Захиалагч нь хэрэглэж дууссан бодисын савыг зориулалтын цэгт түр хадгалж, Нийлүүлэгчид буцаан өгөх ба Нийлүүлэгч нь буцаан авсан хаягдал сав баглаа боодлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч хуульд заасан арга хэлбэрээр устгуулах үүргийг хүлээнэ” гэж нэмэлтээр оруулахаар харилцан тохиролцов.

1.2. Энэхүү Гэрээ нь Үндсэн гэрээний салшгүй нэг хэсэг болох ба Гэрээгээр өөрчлөөгүй бусад заалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

БАТЛАВ.
“М АГРО” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.СОЛОНГО

БАТЛАВ.
“АГРОТРЕЙД ИМПЕКС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ХАНГАЙ

**БАРАА ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ГЭРЭЭ**

2025 оны 03-р сарын 12-ны өдөр № МА-CF-25-004-001 Улаанбаатар хот

Энэхүү Бараа худалдах, худалдан авах гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ийг

нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5573548 тоот дугаартай “М АГРО” ХХК түүнийг төлөөлж Худалдан авалтын албаны дарга Ц.Баттүшиг (цаашид "**Захиалагч**" гэх),

нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох регистрийн 5048664 тоот дугаартай "АГРОТРЕЙД ИМПЕКС" ХХК түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Хангай (цаашид "**Нийлүүлэгч**" гэх) нар (хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Талуудын хооронд байгуулагдсан 2025 оны 01-р сарын 28-ны өдрийн МА-CF-25-004 тоот “Бараа худалдах, худалдан авах гэрээ” (цаашид "**Үндсэн гэрээ**" гэх)-г тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нэмэлт өөрчлөлт**

1.1. Талууд Үндсэн гэрээний Хавсралт №3-т заасан “Барааны нэр төрөл, үзүүлэлт, нэгж үнэ”-г энэхүү Гэрээний Хавсралт №1-т заасны дагуу өөрчлөв.

1.2. Үндсэн гэрээний тусгай нөхцөлийн 2.2-т заасан “Гэрээний нийт үнийн дүн **163,490,000 (Нэг зуун жаран гурван сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөг** байх ба энэ үнийн дүнд импортын татвар, дээжийн зардал, шинжилгээний зардал, НӨАТ, бараа нийлүүлэх байршил, талбайд ачиж, тээвэрлэж хүргэх, буулгах зардал багтсан эцсийн дүн болно" гэснийг “Гэрээний нийт үнийн дүн **175,990,000 (Нэг зуун далан таван сая есөн зуун ерэн мянга) төгрөг** байх ба энэ үнийн дүнд импортын татвар, дээжийн зардал, шинжилгээний зардал, НӨАТ, бараа нийлүүлэх байршил, талбайд ачиж, тээвэрлэж хүргэх, буулгах зардал багтсан эцсийн дүн болно” болгон өөрчлөв.

1.3. Үндсэн гэрээний тусгай нөхцөлийн 3.1 дэх заалтыг “Захиалагч нь төлбөрийг Нийлүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн дараах хуваарийн дагуу төлнө. Үүнд:

1.3.1. Урьдчилгаа төлбөр: Гэрээний нийт үнийн дүнгээс **49,047,000 (Дөчин есөн сая дөчин долоон мянга) төгрөгийг** гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоног дотор;

1.3.2. Дундын төлбөр. Гэрээний нийт үнийн дүнгээс **115,603,000 (Нэг зуун арван таван сая зургаан зуун гурван мянга) төгрөгийг** холбогдох Барааг 2025 оны 04-р сарын 15-ны өдрийн дотор нийлүүлж, хүлээлцэх акт үйлдсэнээс хойш ажлын 15 хоногийн дотор төлнө.

1.3.3. Эцсийн төлбөр: Гэрээний нийт үнийн дүнгийн **11,340,000 (Арван нэгэн сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг** үлдэгдэл бромадиолон-ыг 2025 оны 09-р сарын 15-ны өдрийн дотор нийлүүлж, хүлээлцэх акт үйлдсэнээс хойш ажлын 10 хоногийн дотор тус тус төлнө” болгон өөрчлөв.

1.4. Үндсэн гэрээний тусгай нөхцөлийн 4.3 дэх заалтыг “Нийлүүлэгч нь Барааны 230 литр Бромадиолон ургамал хамгааллын бодисыг 2025 оны 03-р сарын 31-ний өдрийн дотор, 12,100 литр Глифосат ургамал хамгааллын бодисыг 2025 оны 04-р сарын 15-ны өдрийн

*Зураг 21. Нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ байгуулсан байдал*

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Тайланд хугацаанд компанийн ОХШХөтөлбөрийг сайжруулах, дата мониторингийг цаг тухайд нь бүртгэх, сөрөг нөлөөлөл үүссэн эсэхэд хяналт тавих зорилготой “Monitoring Dashboard”-ийг Power BI программ дээр тогтмол хийж бүртгэв.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|---|
| **9.1. Газрын доорхи усны хяналт шинжилгээ** | | | |
| 9.1.1 | **Ашиглалтын гүний худаг:**<br>1. Ерөнхий хими<br>2. Хүнд металл,<br>3. Нян судлалын шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх | 2025 оны 03-р сар , 06-р сар, 09-р сарууддад газар тариалангийн ашиглалтын 1 ширхэг худгаас дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лаборатори болох Ханлаб лабораторид Хүнд металл болон нян судлал, Геоэкологийн хүрээлэнгийн лабораторид ерөнхий химийн шинжилгээг тус тус хийлгүүлсэн. Геоэкологийн хүрээлэнгийн лаборатори нь шинжээчийн дүгнэлттэй гардаг бөгөөд Уг дүгнэлтээр MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлага хангаж байна.<br><br>*Хавсралт 11. Хими, хүнд металл, бактерийн шинжилгээний хариу, Мониторингийн нэгдсэн тайланг хавсаргав.* | <br>*Зураг 22. Усны шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт*<br> |



ЗАХИАЛГА №: 2025/746
ДЭЭЖИЙН ДУГААР: Газар тариалангийн гүний худаг
ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-4203

| № | ЭЛЕМЕНТ | НЭГЖ | ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН | ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/ | СТАНДАРТ АРГА |
|---|---|---|---|---|---|
| 1 | pH | - | 7.94 | 6.5-8.5 | MNS ISO 10523:2001 |
| 2 | Кали ($K^+$) | мг/л | 1.44 | - | MNS 5465:2005 |
| 3 | Натри ($Na^+$) | мг/л | 17.71 | 200.0 | |
| 4 | Кальци ($Ca^{2+}$) | мг/л | 40.92 | 100.0 | MNS ISO 2572-1999 |
| 5 | Магни ($Mg^{2+}$) | мг/л | 11.33 | 30.00 | |
| 6 | Аммони, ($NH_4^+$) | мг/л | <0.10 | 1.50 | MNS ISO 7150-1:2006 |
| 7 | Хлорид, ($Cl^-$) | мг/л | 5.10 | 350.0 | MNS ISO 9297:2005 |
| 8 | Сульфат ($SO_4^{2-}$) | мг/л | 7.41 | 500.0 | MNS 3652-4:1984<br>MNS ISO 11885:2011 |
| 9 | Нитрит ($NO_2^-$) | мг/л | <0.05 | 1.00 | MNS 4431:2005 |
| 10 | Нитрат, ($NO_3^-$) | мг/л | 0.55 | 50.00 | MNS ISO 7890-3:2001 |
| 11 | Карбонат ($CO_3^{2-}$) | мг/л | <1.50 | - | MNS ISO 9963-1:2005 |
| 12 | Гидрокарбонат ($HCO_3^{2-}$) | мг/л | 216.6 | - | |
| 13 | Нийт хатуулаг | мг-экв/л | 2.97 | 7.00 | |
| 14 | Хуурай үлдэгдэл, TDS | мг/л | 218.0 | 1000 | MNS 4423:1997 |
| 15 | Цахиурын хүчил, $H_2SiO_3$ | мг/л | 22.40 | - | MNS 4343-1996 |
| 16 | Исэлдэх чадвар /$KMnO_4$/ | мг$O_2$/л | 6.24 | - | MNS ISO 4889:1999 |
| 17 | Фосфат, $PO_4^{3-}$ | мг/л | 0.07 | 3.5 | MNS ISO 6878:2001 |
| 18 | Фтор, $F^-$ | мг/л | 0.82 | 0.7-1.5 | MNS ISO10359-1:2002 |
| 19 | Хүхэртустөрөгч, $H_2S$ | мг/л | <0.10 | 0.1 | |
| 20 | Үлдэгдэл хлор, $Cl_{чөл}$ | мг/л | <0.10 | 0.2-0.3 | MNS ISO 7393-1:2001 |
| 21 | Булингар | NTU | <10.0 | 1.5 | |
| 22 | Мөнгө, Ag | мг/л | <0.01 | 0.1 | |
| 23 | Хөнгөнцагаан, Al | мг/л | <0.025 | 0.50 | |
| 24 | Мышьяк, As | мг/л | <0.01 | 0.01 | |
| 25 | Бор, B | мг/л | <0.01 | 2.40 | |
| 26 | Бари, Ba | мг/л | 0.01 | 0.70 | |
| 27 | Бериллий, Be | мг/л | <0.001 | 0.0002 | |
| 28 | Кадми, Cd | мг/л | <0.001 | 0.003 | |
| 29 | Кобальт, Co | мг/л | <0.001 | - | |
| 30 | Хром, Cr | мг/л | 0.006 | 0.05 | |
| 31 | Зэс, Cu | мг/л | <0.02 | 2.0 | MNS (ISO) 11885:2011 |
| 32 | Төмөр, Fe | мг/л | <0.03 | 0.3 | |
| 33 | Марганец, Mn | мг/л | <0.01 | 0.1 | |
| 34 | Молибден, Mo | мг/л | 0.006 | 0.07 | |
| 35 | Никель, Ni | мг/л | <0.005 | 0.02 | |
| 36 | Хартугалга, Pb | мг/л | <0.01 | 0.01 | |
| 37 | Сурьма, Sb | мг/л | <0.01 | 0.02 | |
| 38 | Селен, Se | мг/л | <0.01 | 0.04 | |
| 39 | Стронци, Sr | мг/л | 0.32 | 2.00 | |
| 40 | Уран, U | мг/л | <0.03 | 0.03 | |
| 41 | Цайр, Zn | мг/л | <0.01 | 5.0 | |
| 42 | Цианид, $CN_{чөл}$ | мг/л | <0.002 | 0.01 | MNS ISO 6703(II):2005 |
| 43 | Мөнгөн ус, Hg | мг/л | <0.001 | 0.001 | EPA Method 7473 |

**Шинжээчийн дүгнэлт:** Шинжилгээнд ирүүлсэн усны чанар - Монгол улсад мөрдөгдөж буй "Ундны усны MNS 0900:2018 стандарт"-ын шаардлагыг хангаж байна.

Хуудас 2-1

| | | | |
|---|---|---|---|
| 9.1.2 | **Мөрөн голын мониторинг:**<br><br>1. Ерөнхий хими<br>2. Хүнд металл,<br>3. Нян судлалын шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх | Газар тариалангийн үйл ажиллагаанаас Мөрөн голд сөрөг нөлөөлөл байгаа эсэхийг хянах зорилготой 2025 оны 04-р сараас 10-р сарын хооронд 7 удаа сар бүр дээж авч мэргэжлийн итгэмжлэгдсэн лаборатори болох Ханлаб лабораторид Хүнд металл болон нян судлал, SGS ХХК-д Хүнд металл, Геоэкологийн хүрээлэнгийн лабораторид ерөнхий химийн шинжилгээг тус тус хийлгүүлсэн.<br><br>Геоэкологийн хүрээлэнгийн лаборатори нь шинжээчийн дүгнэлттэй гардаг бөгөөд Уг дүгнэлтээр MNS 4586:2024 Гадаргын ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартын шаардлага хангаж байна.<br><br>*Хавсралт 12. Мөрөн голын усны шинжилгээний хариуг хавсаргав.* | <br><br>*Зураг 23. Мөрөн голын шинжилгээний 2025 үзүүлэлт*<br> |





ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 04 сарын 14 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 04 сарын 16 өдөр
Сорьц авсан газрын нэр: Хэнтий аймаг, Хэрлэн сум
Мөрөн гол, 1-р цэг
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "М Агро" ХХК

Солбицлол: X= Y= Гүн: м Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Голын ус

Тодорхойлсон нь:

| Анион | 1дм³ -д байгаа | | | Катион | 1дм³ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 3.9 | 0.11 | 3.7 | $Na^++K^+$ | 13.9 | 0.60 | 20.5 |
| $SO_4^{--}$ | 16.0 | 0.33 | 11.3 | $Ca^{++}$ | 35.7 | 1.78 | 60.2 |
| $NO_2^-$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 6.4 | 0.53 | 17.9 |
| $NO_3^-$ | 0.8 | 0.01 | 0.4 | $NH_4^+$ | 0.7 | 0.04 | 1.3 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 152.5 | 2.50 | 84.6 | $Fe^{+++}$ | 0.05 | 0.00 | 0.1 |
| Дүн | 173.2 | 2.96 | 100.0 | Дүн | 56.8 | 2.96 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 153.7 мг/ дм³ Анион катионуудын нийлбэр: 230.0 мг/ дм³

Ерөнхий хатуулаг 2.31 мг-экв/ дм³ EC: 252 µS/cm
pH: 7.82 TDS: 145 ppm

Исэлдэх чанар 6.24 мг/ дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 10 см Үнэр: үгүй Тунадас: нэвгэр бор
Өнгө: Цайвар бор Амт: *** Булингар: 70.1 NTU

Усны найрлагын томъёо: $M_{0.23}\frac{HCO_3^-85\ SO_4^{2-}11}{Ca^{2+}60\ Na^++K^+21\ Mg^{2+}18}$

Дүгнэлт

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн, булингартай ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүдийг "Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024" стандарттай харьцуулахад кальцийн ионы агууламжаар II, аммонийн ионы агууламжаар III, булингарын хэмжээгээр IV зэрэгт тус тус хамаарч байна.

Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.

Шинжилгээ Гүйцэтгэсэн: Химич, ЭШДаА /Г.Энхжаргал/
Хянаж, баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: /Д.Гэрэлт-Од/

<table>
<tr><th colspan="4">9.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ</th></tr>
<tr><td>9.2.1</td><td>Орчны тоосжилтын хэмжилт хийх (PM10, PM2.5, нийт тоос)</td><td>2025 оны 05-р сар болон 09-р саруудад Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний лабораториор газар тариалангийн талбайд нарийн болон бүдүүн ширхэглэгт тоосонцрын шинжилгээг хийлгүүлсэн.<br><br>Шинжилгээний график үзүүлэлтээр MNS 4585:2016 Агаарын чанарын Техникийн ерөнхий шаардлага стандартын шаардлагыг хангаж байна.<br><br>Хавсралт 13. Агаарын шинжилгээний хариуг хавсаргав.</td><td>

Зураг 24. Агаарын тоосны шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт

</td></tr>
<tr><td>9.2.2</td><td>Гадаад орчны агаарын чанарын \ NO2, SO2, хэмжилт хийх</td><td>2025 оны 05-р сар болон 09-р саруудад Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний лабораториор газар тариалангийн талбайд Хүхэр болон азотын давхар ислийн шинжилгээг хийлгүүлсэн.</td><td>

Зураг 25 . Гадаад орчны агаарын шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт</td></tr>
</table>

| **9.3. Хөрсний судалгаа** | | | |
|---|---|---|---|
| 9.3.1 | 1. Хөрсний агрохими<br>2. Механик бүрэлдэхүүн<br>3. Микро элементийн шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх | Газар тариалангийн 1 цэгээс хөрсний дээжийг 05 болон 09-р сард дээж авч Инженер геодизи ХХК мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.<br><br>*Хавсралт 14. Хөрсний шинжилгээний хариуг хавсаргав.* | Зураг 26–28 (доор) |




*Зураг 26 . Хөрсний химийн шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт*




*Зураг 27. Хөрсний хүнд металын шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт*




*Зураг 28 . Хөрсний механик үзүүлэлтийн шинжилгээний 2024-2025 оны харьцуулсан үзүүлэлт*

## 10. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"М Агро" ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг хариуцан ажилласан.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | |
|---|---|---|---|
| 10.1 | Газар тариалангийн ус ашиглах дүгнэлтийг Усны газраар гаргуулах, Хэрлэн голын сав газраас зөвшөөрөл авах, гэрээ хийх, хэрэглээтэй холбоотой төлбөрийг барагдуулах | 2025 оны 12-р сарын 22-нд ус ашиглах дүгнэлтийг ЗГХА- Усны газраар гаргуулж Хэрлэн голын сав газартай гэрээ байгуулан ажилласан.<br><br>*Хавсралт 15. Ус ашиглах дүгнэлт, гэрээг хавсаргав.* | <br>УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ<br>2025 оны 12 -р сарын 22 -ны өдөр<br>Дугаар Е-2511-000169<br>Улаанбаатар хот Утас: 265528, 265578<br>1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар<br>Оноосон нэр: М АГРО ХХК<br>Улсын бүртгэлийн дугаар:<br>Регистрийн дугаар: 5573548<br>Захирал: Солонго<br>Холбоо барих дугаар: 77779070<br>Факс :<br>И-мэйл хаяг :<br>2.Төслийн нэр байршил<br>Төслийн нэр: Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өлзийт-100" усалгаатай газар тариалан төсөл<br>Байршил: Хэнтий, Хэрлэн, 7-р баг, Ногоон<br>Харьяалагдах сав газар: Хэрлэн голын сав газар<br>Хамаарах салбар: Хөдөө аж ахуй<br>*Зураг 29. Ус ашиглах дүгнэлт* |

| | | | |
|---|---|---|---|
| 10.2 | Тухайн жилийн ус ашиглах тайланг боловсруулан Хэрлэн голын сав газарт тайлагнаж, гэрээ дүгнэх акт үйлдэх | Хэрлэн голын сав газарт 2025 оны 12-р сард Ус ашиглах тайланг хүргүүлсэн. |   |
| 10.3 | Компанийн байгаль орчны бодлогын тухай сургалт зохион байгуулах | Компаний байгаль орчны бодлогыг нийт ажилчдад танилцуулах, түгээх зорилготой сургалтын арга хэмжээг 2025 оны 04-р сард зохион байгуулав. Сургалтад нийт 100 гаруй ажилчид хамрагдав.<br><br>*Хавсралт 16. Нийт ажилчдын сургалтын бүртгэлийг хавсаргав.* | <br>*Зураг 30 . Байгаль орчны сургалт орж буй сургалт* |

| | | | |
|---|---|---|---|
| 10.4 | Хог хаягдлын гэрээг Хэрлэн сумын засаг дарга, Өлзийт тосгонтой байгуулж, төлбөрийг барагдуулах | Нийт төслийн хог хаягдлын гэрээг “Өндөрхаан хот тохижилт” ОНӨААТҮГ-тэй гэрээг байгуулан ажилласан бөгөөд нийт хог хягдлын төлбөр болох 1,944,000 төгрөгийг холбогдох дансанд бүрэн төлсөн.<br><br>*Хавсралт 17. Хог хаягдлын гэрээ болон төлбөр төлсөн баримтыг хавсралтаар хавсаргав.* | <br>“ӨНДӨРХААН ХОТ ТОХИЖИЛТ” ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР<br>БАТЛАВ. ӨНДӨРХААН ХОТ ТОХИЖИЛТ” ОНӨААТҮГ Э.МӨНХБАТ<br>БАТЛАВ. “М АГРО” ХХК-ИЙН САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ Д.МӨНХ-ОД<br>ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ АЖ АХУЙН ГЭРЭЭ<br>2025 оны 04-р сарын 06-ны өдөр № ЖА-ХЛР-25-020 Чингис<br>Энэхүү Хог хаягдлын тухай аж ахуйн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл, заалтууд, Эрүүл ахуйн тухай хуулийн 17-р зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 20.1, 20.2 дах заалтууд Хэрлэн аймгийн, Хэрлэн сумын ИТХ-ын 2023 оны 02 сарын 13 өдрийн 04 тоот тогтоолыг тус тус үндэслэл болгон,<br>**Нэг талаас:** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Централ парк 8 давхар хаягт байрлах, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан **“М Агро” ХХК** (РД: 5573548) (цаашид “**Компани**” гэх),<br>**Ногоо талаас:** Монгол Улс, Хэнтий аймаг, Хэрлэн сум 4-р баг, Сариг, Аж ахуйн хашаа хаягт байрлах **“Өндорхаан Хот Тохижилт”** ОНӨААТҮГ (РД: 9075941) (цаашид “**Гүйцэтгэгч**” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд”, тус тусад нь “Тал” гэх) дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.<br>**Нэг. Нийтлэг үндэслэл**<br>1.1. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Компанийн цуглуулж, тээвэрлэн ирсэн энгийн хог хаягдлыг хянах, булшлах, Компани нь гэрээгээр тохирсон төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөхтэй холбогдсон харилцаанд Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгон зохицуулна.<br>1.2. Хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх, хүрээлэн буй орчныг тогтмол цэвэр байлгах болон цэвэр, эрүүл орчинд амьдрах, ажиллах, орчныг бий болгоход энэхүү Гэрээний зорилго оршино.<br>1.3. Гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.<br>**Хоёр. Гэрээний зүйл, хугацаа**<br>2.1. Компани нь өөрийн үйл ажиллагаанаас гарсан энгийн хог хаягдлыг ангилж, цуглуулж, тээвэрлэх ажлыг зохион байгуулна.<br>2.2. Энэхүү Гэрээг Талууд 2025 оны 01 сарын 01-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ний өдөр дуустал хугацаагаар байгуулав.<br>2.3. Гэрээний 2.2-т заасан хугацаа дуусмагц талууд Гэрээг дүгнэж, шинэчлэн байгуулж болно.<br>**Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл**<br>3.1. Гэрээний үнийг Хэрлэн сумын ИТХ-ын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолын Хавсралт №2-т заасан тарифын дагуу тооцох ба дараахтай адил байна. Үүнд:<br>*Зураг 31 . Хог хаягдлын гэрээ байгуулсан байдал* |
| 10.5 | Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх | Усалгаатай газар тариалангийн БОННҮ-ний дагуу 2 жил тутам хийгддэг Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг “Энвайроментал Комплайнц” ХХК мэргэжлийн аудитын байгууллагаар хийлгүүлэн, санал зөвлөмжийг авсан.<br><br>*Хавсралт 18. Аудитын хийсэн тайланг хавсралтаар хавсаргав.* | <br>Энвайроментал Комплайнц<br>БАЙГАЛЬ ОРЧНЫ<br>АУДИТЫН ТАЙЛАН<br>*Байгаль орчны хууль тогтоомжийн нийцлийн аудит*<br>Аудитын тайлантай танилцаж хүлээн авсан:<br>Нэр / Албан тушаал / Гарын үсэг<br>Б. Солонго / Гүйцэтгэх захирал<br>Б.Оюун / ХЭМАББО менежер<br>Г. Хандсүрэн / Байгаль орчны мэргэжилтэн<br>2025 он<br>*Зураг 25 . Байгаль орчны аудитын дүгнэлт* |

## 11. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

М Агро ХХК- нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдтэй олон арга хэмжээг зохион байгуулан ажилладаг билээ. 2025 онд ЗДТГ болон иргэдээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэхээр бодлого, төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

| № | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|---|
| 11.1 | Өлзийт тосгоны иргэдэд 2025 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний гүйцэтгэлийг танилцуулах | 2025 оны 11-р сарын 27-нд зохион байгуулагдсан Номгон багийн иргэдийн нийтийн 3-р хуралд М Агро ХХК-ийн зүгээс 2025 онд хийгдсэн Байгаль орчны ажлыг танилцуулан, санал зөвлөмжийг авсан.<br><br>Мөн бид олон улсын байгууллагын мэргэжилтэн судлаач нартай хамтран Хэрлэн сумын малчид, Мөрөн сумын малчид, Жаргалтхаан сумын малчид, Өмнөдэлгэр сумын малчидтай уулзаж төслийн үйл ажиллагаанаас малчин иргэдэд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчны асуудал зэргээр санал солилцож уулзалт хийсэн.<br><br>*Хавсралт 19. ИНХ-руу хүргүүлсэн албан хүсэлтийг хавсаргав.* | <br><br>*Зураг 26. Орон нутгийн иргэдэд танилцуулж буй байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| | | |   *Зураг 27. Малчидтай уулзаж буй байдал* |

| | | | |
|---|---|---|---|
| 11.2 | Хэрлэн сумын ЗДТГ-д 2025 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүргүүлэх | 2025 оны 12-р сарын 25-нд Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг холбогдох майлээр хүргүүлж танилцуулсан. | <br>М Агро ХХК-ийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайлан танилцуулах тухай<br>Khandsuren Ganbat<br>To tumendolgor osgonbaatar<br>Cc Oyun Batbuyan<br>Reply Reply All Forward<br>Mon 11/3/2025 2:44 PM<br>You replied to this message on 11/3/2025 2:45 PM.<br>1031-Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-т.pdf 63 KB<br>Усалгаатай газар тариалан БОМТБТ 2025.pdf 18 MB<br>М Агро ХХК Үтрэмийн БОМТБиелэлтийн тайлан 2025.pdf 9 MB<br>Сайн байна уу,<br>М Агро ХХК-ийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайлангуудыг хүргүүлж байна. Та бүхэн байгаль орчны хүрээнд хийгдсэн ажилтай танилцана уу.<br>Баярлалаа.<br>Best regards,<br>**Khandsuren** Ganbat<br>Environmental Specialist<br>Metagro<br>F-8, Central park building, Chinggis Avenue Street,<br>Recreation center, SBD-1, Ulaanbaatar, Mongolia<br>+976-77779070 ; +976-88979850<br>Khandsuren.g@metagro.mn<br>*Зураг 28. Майлээр хүргүүлсэн байдал* |
| 11.3 | Хэнтий аймгийн БОГазарт БОМТ биелэлтийн тайланг танилцуулах | Байгаль орчны төлөвлөгөөний биелэлтийн тайланг 12-р сарын 25-нд танилцуулан дүгнүүлэв. | <br>*Зураг 29. Тайланг танилцуулж буй байдал* |

## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗАРДАЛ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн зардал 10,000,000 төгрөг төлөвлөснөөс 26,963,600төгрөгийг зарцуулсан байна. Дараах дүнд орон нутагт хийж хэрэгжүүлсэн Байгаль орчны нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн дүн ороогүй болно.

| № | Хийгдсэн ажлын чиглэл | Хийгдсэн ажлын тодорхойлолт | Зарцуулалт, төг |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | Хүлэмжийн хийн дата цуглуулалт | Үйл ажиллагааны зардал |
| | | Мөрөн голын судалгаа шинжилгээ | Үйл ажиллагааны зардал |
| | | Усны тоолуурын баталгаажуулалт | 1,500,000 |
| | | Замын тэмдэг , тэмдэглэгээ | 500,000 |
| 2 | Орчны тохижилтын төлөвлөгөө | Тариалангийн талбайг тойруулан ногоон байгууламж, мод бүхий зурвас байгуулах. | 2,500,000 |
| 3 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | Галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ | 500,000 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | Нийтийн их цэвэрлэгээнд ашигласан тээврийн зардал | 1,000,000 |
| 5 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Усны хяналт шинжилгээ | 3,500,000 |
| | | Агаарын чанарын хяналт шинжилгээ | 2,170,000 |
| | | Хөрсний шинжилгээ | 699,600 |
| 6 | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | Ус ашиглах дүгнэлт гаргуулах | 850,000 |
| | | Хог хаягдлын төлбөрийг төлөх | 1,944,000 |
| | | Байгаль орчны аудит | 11,800,000 |
| **Нийт зардал, мян.төг** | | | **26,963,600** |

## 13. НЭМЭЛТЭЭР ХИЙГДСЭН АЖИЛ

| № | Ажлын гүйцэтгэл | Зураг |
|---|---|---|
| 13.1 | Өлзийт тосгоны ЕБС-ын Эко клубын бага, дунд ангийн сурагчдад 2025 оны 06-р сард  Байгаль орчны сургалт орж, сургуулийн хогийн цэгийг засаж сайжруулсан. | <br><br>*Зураг 28. Сургалт орж буй байдал* |

## 14. ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд байгаль орчны дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Тариалангийн талбайн ойн зурвас, хамгаалалтын чиглэлээр 2023-2025 оны хооронд нийт 36.43 км талбайд 100,000 ширхэг модыг тарьж ургуулаад байна.
- Бид усалгаатай газар тариалангийн ус ашиглалтаас “Мөрөн голын экологийн урсац болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг тооцох судалгаа”-г хийлгүүлэх зорилгоор “Сантгидро Консалтинг” ХХК –тай хамтран ажлын даалгаврыг боловсруулан ЗГХА Усны газраар батлуулж, 2025 оны 04-р сараас 08-р сар хүртэл судалгааны ажлыг хийж дуусгаад байна.
- Ургамал хамгаалах бодисын агуулахыг мэргэжлийн гүйцэтгэгч байгууллагаар зураг төслийг гаргуулан сайжруулан хийж дуусгасан.
- 2025 оны 04-р сараас эхлэн Монголика ХХК-аар мэргэжлийн байгууллагатай хамтран газар тариалангийн талбай дахь тарваганы судалгаа болон төслийн ЦДШ-уудаас шувуунд нөлөөллөх нөлөөллийг тогтоох зорилготой үнэлгээ, судалгаа, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гаргуулан ажиллаад байна.
- Усалгаатай газар тариалан төслийн 2 жил тутамд хийгддэг хөндлөнгийн Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаах гүйцэтгүүлэн ажиллав.
- Өлзийт тосгоны ЕБС-ын Эко клубын бага, дунд ангийн сурагчдад Байгаль орчны сургалт орж, сургуулийн хогийн цэгийг засаж сайжруулсан.

# ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

- *Хавсралт 1. Дата цуглуулалтын товч хүснэгт*
- *Хавсралт 2. 1-9-р сарын тоолуурын бичиглэл*
- *Хавсралт 3. Гидрогеологийн усны судалгааны товч тайлан*
- *Хавсралт 4.  Эрүүл ахуйн бүсийн тухай Хэрлэн голын сав газрын албан бичиг*
- *Хавсралт 5. Тарвага болон шувууны  судалгааны товч тайлан*
- *Хавсралт 6.  УХБ үзлэг шалгалтын тайлан 05 болон 09-р сар*
- *Хавсралт 7. Химийн бодисын сургалтад хамрагдсан бүртгэл*
- *Хавсралт 8. Газар тариалангийн ажилчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч буй жишиг хуудас 7-10 сар*
- *Хавсралт 9. 2025 оны Аюултай хог хаягдлын  бүртгэл, УХБ-ын зарцуулалтын тайлан,  Элемент ХХК-ийн гэрээ*
- *Хавсралт 10. Ургамал хамгаалах бодис нийлүүлсэн байгууллагатай хийсэн хог хаягдлын нэмэлт гэрээ*
- *Хавсралт 11. Усны шинжилгээний хариу, Мониторингийн нэгдсэн тайлан*
- *Хавсралт 12. Мөрөн голын усны шинжилгээний хариу*
- *Хавсралт 13. Агаарын шинжилгээний хариу*
- *Хавсралт 14. Хөрсний шинжилгээний хариу*
- *Хавсралт 15. Усны нөөцийн зөвлөлийн хуралд орох тухай  албан хүсэлт- М Агро ХХК*
- *Хавсралт 16. Байгаль орчны бодлогын сургалтад хамрагдсан бүртгэл*
- *Хавсралт 17. Хот тохижилтын хог хаягдлын гэрээ болон төлбөр төлсөн баримт, ТМЛ-гэрээ*
- *Хавсралт 18.  Хөндлөнгийн аудит хийсэн дүгнэлт*
- *Хавсралт 19.  ИНХ-руу хүргүүлсэн албан хүсэлт- М Агро ХХК*